- B. Хэвээ усаар зайлах
- C. Илүүдэл усыг сэгсэрч агаараар шүршиж зайлуулах
- D. Хэвийг доош нь харуулж байршуулах
- E. Хэвний хугарч гарсан хэсгүүдийг бэхлэх

/217./ Шүдний тойрон эдийн үйлийн хэт ачаалал хэдийд үүсэх вэ ?

- A. Зарим шүд унасан, захилах байрлал өөрчилөгдсөн
- B. Хоршилтын гажиг үүссэн
- C. Авагддаг ба авагддаггүй шүдэлбэр буруу хийгдсэн
- D. Авагддаггүй шүдэлбэр буруу хийгдсэн
- E. Зарим шүд унасан, байрлал өөрчилөгдсөн

/218./ Зуултын өндөрийг зөв тодорхойлсон эсэхийг яаж шалгах вэ ?

- A. Рентген зураг
- B. Нүүрэн дээрх хэмжил зүйн аргаар
- C. Амны хөндийн дотоод үзлэг
- D. Дэлгэмэл зураг
- E. Ерөнхий үзлэг

/219./ Хоршихуй аль ойлголтонд орохгүй вэ?

- A. Зуулт
- B. Харьцаа
- C. Тайван байдал
- D. Хавирахуй
- E. Шүдлэхүй

/220./ Бэлэн болсон хуванцар бүрээсийг өвчтний аманд суулгаж өгөхийн өмнө ямар нөхцөлд хадгалах вэ?

- A. Усанд
- B. Чийгтэй даавуунд
- C. Битүү саванд хадгална
- D. Ариун газар
- E. Нөхцөл чухал биш

/221./ Том хэмжээний согогтой байх нөхцөлд нүүрний хиймэл суулгацыг ямар байдлаар хийвэл дээр вэ?

- A. 1 хэсгээс бүрддэг байх
  - B. 2 хэсгээс бүрддэг байх
  - C. Олон бүрдэлтэй байх
  - D. 3 хэсгээс бүрддэг байх
  - E. 4 хэсгээс бүрддэг байх
- /222./ Хиймэл эрхтнийг юугаар хийдэг вэ?
- A. Зөөлөн хуванцар
  - B. Хатуу хуванцар
  - C. Силикон
  - D. Зөөлөн хатуу хуванцарыг хослуулж
  - E. Зөөлөн хуванцарыг хослуулж
- /223./ Зөөлөн хуванцарын бүрдэл?
- A. Поливинилхлор шингэн ба дибутилфталатын нунтаг
  - B. Поливинилхлор нунтаг ба дибутилфталатын шингэн
  - C. Поливинилхлор дибутилфталатын нунтаг
  - D. Поливинилхлор нунтаг бутилфталатын шингэн
  - E. Поливинил ба дибутилфталатын шингэн
- /224./ Хамар хийх нунтаг шингэний харьцаа?
- A. Нунтаг 3-5гр шингэн 35-38%
  - B. Нунтаг 10-15гр шингэн 38-40%
  - C. Нунтаг 1-15гр шингэн 33-40%
  - D. Нунтаг 3-10гр шингэн 35-40%
  - E. Нунтаг 12-15гр шингэн 30-38%
- /225./ Хиймэл ухархайг тоогтоох арга?
- A. Төмөр тогтоогч
  - B. Углуурга
  - C. Нүдний шил
  - D. Тогтоогч
  - E. Шанаавч
- /226./ Хиймэл эрхтэн хийх хугацаа?
- A. Хагалгааны дараа шууд
  - B. Хагалгааны дараа 6 сарын дотор
  - C. Хагалгааны шарх эдгэснээс хойш 6 сарын дараа
  - D. Хагалгааны дараа 3 сарын дотор
  - E. Хагалгааны шарх эдгэснээс 3 сарын дараа
- /227./ Овтуратор гэж юу вэ?
- A. Тагнайн тээг
  - B. Шанааны нум
  - C. Ооч
  - D. Хамар
  - E. Тогтоогч
- /228./ Урагт анхдагч амны хөндийн эрхтэний эх үүсвэр бий болох хугацаа?
- A. 6-7 долоо хоног
  - B. 5-6 долоо хоног
  - C. 7-8 долоо хоног
  - D. 4-7 долоо хоног
  - E. 2-4 долоо хоног
- /229./ Амны хөндийн эрхтэн бүрэн хэлбэржиж дуусах хугацаа?
- A. 12 дахь долоо хоног
  - B. 6-7 дахь долоо хоног
  - C. 7-8 дахь долоо хоног
  - D. 6-8 дахь долоо хоног
  - E. 5-6 дахь долоо хоног
- /230./ Уруул тагнайн төрөлхийн согогийн монголд тохиолдох тохиолдол?
- A. 1341 төрөлтөд 1

- B. 1000 төрөлтөд 1
- C. 1000 төрөлтөд 3
- D. 1341 төрөлтөд 2
- E. 1321 төрөлтөд 3

/231./ Анхны тагнайн согогийг арилгах зэмсэг хийсэн эрдэмтэний нэрийг хэлнэ үү.

- A. Амбруаз Паре
- B. Кез
- C. Щельдский
- D. Фошор
- E. Амбруаз

/232./ Хүний биед байдаг бүх чиглэлд хөдөлгөөн хийдэг цорын ганц үе ?

- A. Өвдөг
- B. Тохой
- C. Хүзүү
- D. Эрүү
- E. Хоншоор

/233./ Петросовын чигийг аль шүднүүдэд тавих вэ?

- A. 16, 17, 46, 47
- B. 14, 15, 44, 45
- C. Бүх шүднүүдэд
- D. 16, 27, 36, 47
- E. 16, 27, 46, 37

/234./ Эмнэл зүйн аливаа нөхцөлд шүдгүй хоншоор эрүүнээс тухайн өвчтөнд тохирсон халбагаар ямар хэв авах вэ?

- A. Анатомын хэв болон үйлтэй хэв
- B. Давхар хэв
- C. Тусгай хэв
- D. Хосолмол хэв

/235./ Гербстийн 1-р сорил аль нь вэ?

- A. Амыг том ангайлган залгиулна
- B. Доод уруулын дотор талаар хэлийг гүйлгэнэ Амыг том ангайлган залгиулна
- C. Амыг хагас ангайлгасан үед хэлнийхээ үзүүрээр 2 талын хацарт хүрэх
- D. Хэлийг хамрын үзүүррүү чиглүүлэн гаргах
- E. Нүүрний булчинг идвэхтэй хөдөлгөөнд оруулж уруулыг ургаш цорвойлгох

/236./ Гербстийн 2-р сорил аль нь вэ? (шүдгүй эрүү)

- A. Амыг том ангайлган залгиулна
- B. Доод уруулын дотор талаар хэлээ гүйлгэх
- C. Амыг хагас ангайсан үед хэлнийхээ үзүүрээр 2 талын хацарт хүрэх
- D. Хэлийг хамрын үзүүррүү чиглүүлэн гаргах
- E. Нүүрний булчинг идвэхтэй хөдөлгөөнд оруулж уруулыг ургаш цорвойлгох

/237./ Гербстийн 3-р сорил аль нь вэ? (шүдгүй эрүү)

- A. Амыг хагас ангайсан үед хэлний үзүүрээр 2 талын хацарт хүрэх
- B. Амыг том ангайлган залгиулна
- C. Доод уруулын дотор талаар хэлээ гүйлгэх
- D. Хэлийг хамрын үзүүлүү чиглүүлэн гаргах
- E. Нүүрний булчинг идвэхтэй хөдөлгөөнд оруулж уруулыг ургаш цорвойлгох

/238./ Гербстийн 4-р сорил аль нь вэ? (шүдгүй эрүү)

- A. Амыг том ангайлган залгиулна
- B. Доод уруулын дотор талаар хэлийг гүйлгэнэ
- C. Амыг хагас ангайсан үед хэлнийхээ үзүүрээр 2талын хацарт хүрэх
- D. Хэлийг хамрын үзүүрлүү чиглүүлэн гаргах
- E. Нүүрний булчинг идвэхтэй хөдөлгөөнд оруулж уруулыг ургаш цорвойлгох

/239./ Гербстийн 5-р сорил аль нь вэ? (шүдгүй эрүү)

- A. Амыг том ангайлган залгиулна
- B. Доод уруулын дотор талаар хэлийг гүйлгэнэ

- C. Амыг хагас ангайсан үед хэлнийхээ үзүүрээр 2талын хацарт хүрэх  
D. Хэлийг хамарын үзүүрлүү чииглүүлэн гаргах  
E. Нүүрний булчинг идвэхтэй хөдөлгөөнд оруулж уруулыг ургаш цорвойлгох
- /240./ Шүдгүй хоншоороос тусгай халбага бэлтгэж үйлдэлтэй хэв авахад хийх Гербстийн 1-р сорил аль нь вэ?  
A. Амыг том ангайлгана  
B. Хацарыг дотгош соруулна  
C. Уруулыг ургаш дорвойлгоно  
D. Амыг ангайлгана  
E. Уруулыг дотогш дорвойлгоно
- /241./ Шүдгүй хоншоороос тусгай халбага бэлтгэн үйлдэлтэй хэв авахад хийх Гербстийн 3-р сорил аль вэ?  
A. Амыг том ангайлгана  
B. Уруулыг ургаш дорвойлгоно  
C. Хацарыг дотгош соруулна  
D. Амыг хагас ангайсан үед хэлнийхээ үзүүрээр 2 талын хоцорч хүрэх  
E. Бүгд зөв
- /242./ Бүрэн шүдгүйдлийн үед анатоми-физиологийн аргаар юуг тодорхойлдог вэ?  
A. Зуултын өндөр  
B. Эмнэл зүйн өндөр  
C. Нүүрний өндөр  
D. Хамрын өндөр  
E. Хоршилтын өндөр
- /243./ Эрүүний зөвхөн босоо чиглэлийн хөдөлгөөнийг сэргээгч багажийг юу гэдэг вэ?  
A. Хамхилуур  
B. Артикулятор  
C. Бонвилийн үелүүр  
D. Үелзүүр  
E. Үелүүр
- /244./ Эрүүний бүх хөдөлгөөнийг их бага ямар нэг хэмжээгээр орлон сэргээгч багажийг юу гэдэг вэ?  
A. Үелүүр  
B. Хамхилуур  
C. Артикулятор  
D. Бонвилийн үелүүр  
E. Хамхуурь
- /245./ Салст бүрхүүлийн зөөлөн чанарыг ашиглан ,судаслаг бүсийг тодруулан хэв авах аргачлал аль нь вэ?  
A. Идэвхгүй хөдөлгөөний тусламжтайгаар үйлийн хэв авах аргачлал  
B. Даралттай хэв авах аргачлал  
C. Үйлдэлтэй авсан хэв авах аргачлал  
D. Тусгай халбага бэлтгэж хэв авах  
E. Үйлдэлтэй хэв авах аргачлал
- /246./ Хугарсан ясыг эвлүүлж барих үүрэгтэй зөв байрлалд орох хүртэл нь дотогш болон гадагш татах зэмсгүүдийг ямар зэмсэг гэх вэ?  
A. Тогтоогч  
B. Чиглүүлэгч  
C. Зохицуулагч  
D. Орлогч  
E. Хосолмол
- /247./ Чигийг бэхлэн тогтооход хэрэглэдэг зэс, хөнгөн цагаан утасны хэмжээ?  
A. Урт 6-7см, өргөн 0,4-0,6 мм  
B. Урт 6-7 см өргөн 0,6-0,8мм  
C. Урт 7-8 см өргөн 0,4-0,6мм

D. Урт 5-7 см өргөн 0,5-0,8мм

E. Урт 4-7 см өргөн 0,3-0,6мм

/248./ Эрүү хоншоорын түүшин сэртэнгийн хугарал, эрүүний дунд биеийн хугарал, шүдний эгнээний хүрээнээс хальж гараагүй хугарлууд, босоо хэвтээ чиглэлд шилжин зөрөөгүй хугаралд ямар чиг тавих вэ?

A. Дэгээ чиг

B. Гөлгөр чиг

C. Дэгээ болон налуу хавтгай чиг

D. Хөндлөвчтэй гөлгөр чиг

E. Дэгээ болон хавтгай чиг

/249./ Шүдний эгнээний согогийн үед эрүүний түүшин сэртэнгийн хажуугийн хэсэг хугарч хэл тал руу шилжин байрласан бол ямар зэмсэг хэрэглэх бэ?

A. Ванкевичийн чиг

B. Веберийн чиг

C. Буйлны шахмал цоорхой чиг

D. Гөлгөр утсан чиг

E. Буйлны шахмал чиг

/250./ Оочны хавьд согог үүссэн хугарлыг эмчлэх хөшүүрэг бүхий зохицуулагч зэмсгийг хэн зохиосон вэ?

A. Курляндский

B. Ванкевич

C. Порт

D. Катц

E. Шер

/251./ Хоншоорын хугарлын үед хэргэлдэг эрүүний шахмал зэмсгийг юу гэдэг вэ?

A. Ванкевичийн чиг

B. Веберийн чиг

C. Степановын чиг

D. Портын чиг

E. Катцийн чиг

/252./ Эрүүний хугарсан хэсгүүдийг тогтоох хуванцар шахмал чигийн нэрийг нэлнэ үү.

A. Курлендский

B. Вебер

C. Ванкевич

D. Порт

E. Катц

/253./ Шүдгүй эрүү хоншоорын хугарлын үед өвчтөн шүдэлбэргүй үед ямар чиг хэрэглэх вэ?

A. Катцын зэмсэг

B. Веберийн чиг

C. Порт Гуннигийн чиг

D. Ванкевичийн чиг

E. Курлендский

/254./ Тав хүртлэх насны хүүхдийн шүдний хугарлын үед хийгдэх согог заслын эмчилгээг хэлнэ үү.

A. Хуванцар малгайвч

B. Утсан чиг

C. Матмал чиг

D. Бүрээс

E. Хуванцар чиг

/255./ Шүдний хугарсан сурвалж чиг тавьснаас хойш хэдий хугацаанд бороолох вэ?

A. 2-4 сар

B. 3-5 сар

C. 1,5-2 сар

D. 2-3 сар

E. 3-4 сар

/256./ Булгарсан шүдийг буцааж суулгахад хэдий хугацаанд бэхлэгдэх вэ?

- A. 2-3 долоо хоног
- B. 4-6 долоо хоног
- C. 2-7 долоо хоног
- D. 3-5 долоо хоног
- E. 2-4 долоо хоног

/257./ Булгарсан шүдийг буцааж суулгахдаа ямар бэхэлгээг ашиглах вэ?

- A. Хуванцар малгайвч
- B. Утсан чиг
- C. Матмал чиг
- D. Бүрээс
- E. иг

/258./ Толгойн боолтны цонхыг хаана гаргах вэ?

- A. Духны хэсэг
- B. Дагзны хэсэг
- C. Зулайн хэсэг
- D. Чамархайн хэсэг
- E. Хамрын хэсэг

/259./ Лефор 1,2, 3 ийн үед татлага, хөшүүрэг хийх утас ямар байх вэ?

- A. 3-4мм голчтой ган утас
- B. 3-4мм голчтой хөнгөн цагаан утас
- C. 2-3мм голчтой ган утас
- D. 2-3мм хөнгөн цагаан утас
- E. 2-4мм голчтой хөнгөн цагаан утас

/260./ Хамар болон хамарын дайвар хөндий самалдагны түвшинд байх суборбитал хоншоорын хугарал Лефорын хэддүгээр ангилал вэ?

- A. Лефор -1
- B. Лефор -2
- C. Лефор -3
- D. Лефор -4
- E. Лефор -5

/261./ Шүдний хатуу эдийн эмгэг элэгдэлийн үед үүсэж буй эмнэл зүйн ерөнхий шинжэд аль нь хамаарах вэ?

- A. Нүүрний доод өндөр нэмэгдэх
- B. Уруулын жимийлт багасах
- C. Костины хам шинж илэрэх
- D. Хамар уруулын нуглаа тэнийх
- E. Хамар уруул тэнийх

/262./ Булчингийн үнэмлэхүй хүч гэдэг нь булчинг дээд зэргээр ..... үед үүсч байгаа даралтыг хэлнэ.

- A. Агших
- B. Сулрах
- C. Чангарах
- D. Хатуурах
- E. Хэвийн

/263./ А.Я.Катцын тодорхойлсноор үелэхүй гэж юуг хэлэх вэ?

- A. Бүх шүдний эгнээ баруун талдаа их бага ямар нэг хугацаагаар хоорондоо харьцах байрлал хөдөлгөөн
- B. Бүх шүднүүд бүх чиглэлээр харьцаж байрлал хөдөлгөөн
- C. Бүх шүдний эгнээ зүүн талдаа их бага ямар нэг хугацаагаар хоорондоо харьцах байрлал хөдөлгөөн
- D. Бүх шүднүүд урагшаа,арагшаа харьцах байрлал хөдөлгөөн
- E. Бүх шүдний эгнээ их бага ямар нэг хугацаагаар хоорондоо харьцах байрлал хөдөлгөөн

/264./ Эрүү урагш хөдлөх нөхцөлд үений толгойн дайран өнгөрөх замыг нэрлэнэ үү?



- A. Үений дагуу зам
- B. Үүдэн шүдний дагуу зам
- C. Хорших хавтгай дагуу
- D. Үений тууш зам
- E. Үений ташуу зам

/265./ Эрүүний үений тууш замыг ямар аргаар тодорхойлдог вэ?

- A. Үений хөндлөн замын өнцгөөр
- B. Үений босоо замын өнцгөөр
- C. Хорших хавтгайн өнцгөөр
- D. Үений толгой,шүдний эгнээний хорших хавтгайн хооронд үүсэх өнцгөөр
- E. Үений толгой,шүдний хорших хавтгайн хоорондох өнцгөөр

/266./ Голын үүдэн шүднүүдийн шилжих байрлалаас үүссэн муруйнуудын огтлолцлоос хамгийн их мохоо өнцөг үүсдэг. Энэ өнцгийн нэр.

- A. Үений хажуу замын өнцөг-Беннет
- B. Үүдэн шүдний хөндлөн замын өнцөг-Шот
- C. Үүдэн шүдний дагуу замын өнцөг-Гизи
- D. Бонвилын өнцөг
- E. Үүдэн шүдний дагуу замын өнцөг

/267./ Шүлс нь өөртөө уураг, эрдэс, ферментүүдийг агуулдаг уу?

- A. Агуулдаг
- B. Агуулдаггүй
- C. Хэвийн
- D. Тодорхойгүй
- E. Маш бага

/268./ Үений хажуу замын өнцөг дунджаар хэдэн градус байдаг вэ?

- A. 18 градус
- B. 17 градус
- C. 16 градус
- D. 15 градус
- E. 14 градус

/269./ Үүдэн шүдний хөндлөн замын өнцөг буюу Шот-ын өнцгийн утга хэд вэ?

- A. 40-50 градус
- B. 17-27 градус
- C. 100-110 градус
- D. 45-55 градус
- E. 35-45 градус

/270./ Бүх шүдэнд хамаарагдах хоршилтын шинж тэмдгийг хэлнэ үү?

A. Хоншоор болон эрүүний голын үүдэн шүднүүдийн дундуур өнгөрч байгаа дунд шугам 1 дагуу хавтгайд байрлана

B. Дээд шүдний тагнайн төвгөр доод шүдний тууш ховилд, доод талын шүдний хацрын төвгөр дээд шүдний тууш ховилд сууна

C. Дээд талын I арааны хацрын ар талын төвгөр доод талын ийм нэртэй арааны хацрын ар төвгөр болон доод талын II арааны хацрын урд төвгөр 2-н дунд байрлана

D. Үүдэн бүлэг шүднүүд эрүүний ижил нэрт шүдний гадна талаар араа бүлэг шүднүүд эрүүний ижил нэрт шүднүүдийн гадна талаар бүрхэж байрлана.

E. Хоншоор голын үүдэн шүднүүдийн дундуур өнгөрч байгаа дунд шугам 1 дагуу хавтгайд байрлана

/271./ Дараах хоршилтын шинжүүдээс үүдэн шүдэнд хамаарах шинжийг хэлнэ үү?

A. Хоншоор болон эрүүний голын үүдэн шүднүүдийн дундуур өнгөрч байгаа дунд шугам 1 хавтгайд байрлана

В. Дээд шүдний тагнайн төвгөр доод шүдний тууш ховилд, доод талын шүдний хацрын төвгөр дээд шүдний тууш ховилд сууна

С. Дээд талын I арааны хацрын ар талын төвгөр доод талын ийм нэртэй арааны хацрын ар төвгөр болон доод талын II арааны хацрын урд төвгөр 2-н дунд байрлана

Д. Дээд шүд бүр нь доод талын адил нэртэй шүд болон түүний ар талд оршиж байгаа шүдтэй хавсарч хоршино

Е. Хоншоор болон эрүүний шүднүүдийн дундуур өнгөрч байгаа дунд шугам 1 хавтгайд байрлана

/272./ Дараах хоршилтын шинжүүдээс араа шүдний хөндлөн чиглэлд хамаарах шинжийг хэлнэ үү?

А. Хоншоор болон эрүүний голын үүдэн шүднүүдийн дундуур өнгөрч байгаа дунд шугам 1 дагуу хавтгайд байрлана

В. Дээд шүдний тагнайн төвгөр доод шүдний тууш ховилд, доод талын шүдний хацрын төвгөр дээд шүдний тууш ховилд сууна

С. Дээд талын I арааны хацрын ар талын төвгөр доод талын ийм нэртэй арааны хацрын ар төвгөр болон доод талын II арааны хацрын урд төвгөр 2-н дунд байрлана

Д. Дээд шүд бүр нь доод талын адил нэртэй шүд болон түүний ар талд оршиж байгаа шүдтэй хавсарч хоршино

Е. Хоншоор болон эрүүний шүднүүдийн дундуур өнгөрч байгаа дунд шугам 1 дагуу хавтгайд байрлана

/273./ Дараах хоршилтын шинжүүдээс араа шүдний дагуу чиглэлд хамаарах шинжийг хэлнэ үү?

А. Хоншоор болон эрүүний голын үүдэн шүднүүдийн дундуур өнгөрч байгаа дунд шугам 1 дагуу хавтгайд байрлана

В. Дээд шүдний тагнайн төвгөр доод шүдний тууш ховилд, доод талын шүдний хацрын төвгөр дээд шүдний тууш ховилд сууна

С. Дээд талын I арааны хацрын ар талын төвгөр доод талын ийм нэртэй арааны хацрын ар төвгөр болон доод талын II арааны хацрын урд төвгөр 2-н дунд байрлана

Д. Дээд шүд бүр нь доод талын адил нэртэй шүд болон түүний ар талд оршиж байгаа шүдтэй хавсарч хоршино

Е. Хоншоор болон эрүүний шүднүүдийн дундуур өнгөрч байгаа дунд шугам 1 дагуу хавтгайд байрлана

/274./ Эдгээрээс муруй зуулт аль нь вэ?

А. Дээд доод үүдэн шүд хоршихгүй байх

В. Доод талын араа шүдний хацрын төвгөр дээд талыхаас гадагш түрж гарсан байх

С. Дээд талын үүдэн шүд доод талынхыг бараг бүхэлд нь халхалсан байх

Д. Доод араа шүдний хацрын төвгөр дээд талын араа шүдний төвгөрөөс давж гарсан байх

Е. Дээд талын шүд доод талынхыг бараг бүхэлд нь халхалсан байх

/275./ Муруй зуултын үед үүдэн шүднүүд хэвийн хорших уу?

А. Хоршино

В. Хоршихгүй

С. Хэвийн

Д. Зөрж хоршино

Е. Давж хоршино

/276./ Хуурамч орсгой гэж юуг хэлэх вэ?

А. Дээд талын I арааны хацрын урд төвгөр доод талын мөн ийм төвгөр дээр харьцах

В. дээд талын I арааны хацрын урд төвгөр доод II бага арааны төвгөр дээр харьцах

С. Араа шүднүүдийн хоршилт хадгалагдаж дээд доод үүдэн шүднүүдийн хоршилт өөрчлөгдөх

D. Дээд I арааны хацрын төвгөр доод I арааны хацрын урд төвгөрийн дунд үүссэн атираан дээр харьцах

Е. Араа шүднүүдийн хоршилт хадгалагдаж шүднүүдийн хоршилт өөрчлөгдөх

/277./ Дараах эмгэг зуултуудаас альных нь үед хоол бутлахад их үүрэг гүйцэтгэснээс болж хэл томордог вэ?

A. Орсгой

B. Шаамий

C. Зөрмөл

D. Заалхай

E. Гүн

/278./ Ямар зуултын үед хоншоор эрүүний түүшин сэртэн болон үүдэн шүднүүд хамт нэг түвшинд урагш түрсэн, үүдэн шүднүүдийн түүшин сэртэн хамт дотогш хазайсан байх вэ?

A. Шулуун

B. Хам орсгой

C. Зөрмөл

D. Шаамий

E. Заалхай

/279./ Хоол хүнсийг зулгааж тасдахад зохицсон хэлбэртэй шүдийг нэрлэ.

A. Төвийн үүдэн шүд

B. Хажуугийн үүдэн шүд

C. Соёо

D. Бага араа

E. Их араа

/280./ Хоёр сурвалжтай шүдийг нэрлэ

A. Төвийн үүдэн шүд

B. Хажуугийн үүдэн шүд

C. Соёо

D. Бага араа

E. Их араа

/281./ Зажлуурын булчинг үйлийн хувьд хэрхэн ангилж болох вэ?

A. Эрүүг дээш өргөх

B. Эрүүг доош буулгах

C. Эрүүг урагш хойш хөдөлгөх

D. Эрүүг баруун тийш хөдөлгөх

E. Эрүүг зүүн тийш хөдөлгөх

/282./ Эмнэл зүйн цөгц гэж юу вэ?

A. Шүдний эмтэрсэн хэсэг

B. Шүдний төвгөр

C. Шүдний буйлнаас дээш гарсан хэсэг

D. Паалангаар хучигдсан шүдний хэсэг

E. Шүдний ёзоор

/283./ Шүдний дисдопи гэж юу вэ?

A. Эрт шүдлэх

B. Оройтож шүдлэх

C. Шүдний байрлал өөрчлөгдөх

D. Шүдний паалангийн өнгө өөрчлөгдөх

E. Шүдний хэлбэрийн өөрчлөлт

/284./ Английн 1-р ангиллын зуултын үед хамар уруулын нугалаас ямар байх вэ?

A. Тэнийнэ

B. Гүнзгийрнэ

C. Хэвийн

D. Уртасна

/285./ Хам орсгой зуултын онцлог шинжийг сонгоно уу

- A. Дээд доод үүдэн шүднүүд дотогш налсан зуулт
- B. Дээд доод үүдэн шүднүүд гадагш орсойсон зуулт
- C. Үүдэн шүднүүд зөрсөн
- D. Үүдэн шүднүүд ирмэгээрээ хоршисон
- E. Үүдэн шүднүүд заалхайтсан

/286./ Байнгын шүдний зуултыг юу тодорхойлдог вэ?

- A. Шүдний тоо
- B. Шүдний эгнээний хэлбэр
- C. Эрүүний хэмжээ
- D. Шүдний эгнээний нийлэх байдал, харьцаа
- E. Зуултын өндөр

/287./ Физиологийн зуултанд дараах орно

- A. Ортогнатик, шулуун, заалхай
- B. Ортогнатик, шаамий, орсгой, шулуун
- C. Ортогнатик, бипрогнатик, шулуун
- D. Ортогнатик, шаамий, орсгой
- E. Зөвхөн ортогнатик зуулт

/288./ Шүд саатах нь ямар гажигт орох вэ?

- A. Байрлалын
- B. Шүдлэх хугацааны
- C. Хэлбэрийн
- D. Бүтцийн
- E. Шүдлэх дэс дараалалын

/289./ Босоо чиглэлээр үүсэх шүдний зуултын гажгийг сонго

- A. Шаамий, орсгой
- B. Зөрмөл
- C. Орсгой, муруй
- D. Зөрмөл, заалхай
- E. Шаамий, муруй

/290./ Дагуу чиглэлээр үүсэх шүдний зуултын гажгийг сонго

- A. Эрүүл, шаамий
- B. Шаамий, муруй
- C. Муруй, орсгой
- D. Шаамий, орсгой
- E. Заалхай, эрүүл

/291./ Араа шүднүүд урагш байрласныг ямар хавтгайд тодорхойлох вэ?

- A. Урд
- B. Дагуу
- C. Хөндлөн
- D. Хоршихуйн
- E. Босоо

/292./ Эрүүний үений өвчний үед гажиг заслын зэмсгийг хэрэглэх хугацаа ямар байх вэ?

- A. 1 долоо хоног
- B. 1 сар
- C. 2 долоо хоног
- D. 6 сар
- E. 1 жил

/293./ Шүдний хатуу эдийн эмгэг элэгдлийн хэлбэр ямар хүчин зүйлээс хамаарах вэ?

- A. Зуултын төрлөөс
- B. Хорших төлвөөс
- C. Шүдний хэлбэр хэмжээнээс
- D. Шүдний эгнээний нумын хэлбэрээс
- E. Буруу зуршлаас

/294./ Шүдний хатуу эдийн эмгэг элэгдэлтэй өвчтөнд илрэх эмнэл зүйн шинжийг хэлнэ үү

- A. Цоорол
  - B. Шүдний өнгөний өөрчлөлт
  - C. Шүдний тулгуур эдийн эмгэг
  - D. Зөөлцийн үрэвсэл
  - E. Шүдний хэт мэдрэгшил
- /295./ Шүдний эмгэг элэгдлийн бүх хэлбэрийн үед ямар шүдэлбэр хийх вэ?
- A. Хэвлэмэл
  - B. Цутгамал
  - C. Шатаамал
  - D. Шахмал
  - E. Холимог
- /296./ Үйл зүйн үйлчилгээтэй зэмсэг нь
- A. Винт идэвхжүүлснээр
  - B. Резинэн татлаг хийснээр
  - C. Төмөр утсыг идэвхжүүлснээр
  - D. Булчин агшихад
  - E. Уруулын нумыг тэлснээр
- /297./ Хосолмол үйлчилгээтэй зэмсэг нь
- A. Функциональ хэсэгтэй зэмсэг
  - B. Механик хэсэгтэй зэмсэг
  - C. Механик ба функциональ хэсэгтэй зэмсэг
  - D. Резинэн татлагтай зэмсэг
  - E. Пүрш бүхий зэмсэг
- /298./ Эрүүний хугарлын үед гарах эмнэл зүйн үндсэн шинж аль нь вэ?
- A. Толгой өвдөх
  - B. Хамраас цус гарах
  - C. Зуулт өөрчлөгдөх
  - D. Хоншоор эмгэг хөдөлгөөнтэй болох
  - E. Түүшин сэртэнгийн салст урагдах
- /299./ Хоншоор, гурамсан мэдрэлийн аль салаагаар мэдрэлжүүлэгдэх вэ?
- A. I салаа
  - B. II салаа
  - C. III салаа
  - D. IV салаа
  - E. E. V салаа
- /300./ Төвгөрийн мэдээгүйжүүлэлтийн үед мэдээгүйжих шүд аль нь вэ?
- A. 1.8,1.7,1.6,2.6,2.7,2.8
  - B. 1.8,2.8
  - C. 1.8,1.7,1.6,1.5,1.4,2.4,2.5,2.6,2.7,2.8
  - D. 1.7,1.6,2.6,2.7
  - E. 1.3,1.2,1.1,2.1,2.2,2.3
- /301./ Ухархайн доод мэдээгүйжүүлэлтийн үед дээд түүшийн аль салаа мэдээгүйжих вэ?
- A. Дунд болон арын
  - B. Урд болон арын
  - C. Урд болон дунд
  - D. Дээд
  - E. Доод
- /302./ Хэлний угийн мэдээгүйжүүлэлтийг хаана хийх вэ?
- A. Гүрээний нүхэнд
  - B. Зуйван нүхэнд
  - C. Сэртэнгийн нүхэнд
  - D. Дугуй нүхэнд
  - E. Ухархайн доод нүхэнд
- /303./ Хөдөлгөөний салааг хэзээ мэдээгүйжүүлэх вэ?
- A. Шанаа яс татах үед

- B. Үрэвслийн улмаас ам ангайлт хязгаарлагдсан үед
  - C. Хамрын яс татах
  - D. Сиалографи хийхэд
  - E. Сорвижилтын улмаас ам ангайлт хязгаарлагдсан үед
- /304./ Ямар салаанд хориг хийх зорилгоор Бершегийн мэдээгүйжүүлэлтийг хийх вэ?
- A. Хэлний болон доод түүшийн мэдрэл
  - B. Хэл, хацар, доод түүшийн мэдрэл
  - C. Гурамсан мэдрэлийн хөдөлгөөний салаа
  - D. Хэлний мэдрэл
  - E. Доод түүшийн мэдрэл
- /305./ Угийн мэдээгүйжүүлэлт хийх заалтыг нэрлэнэ үү?
- A. Гэмтэл бага учруулах мэс заслын үед
  - B. Удаан хугацааны мэс заслын үед
  - C. Гэмтэл бага учруулах ба удаан хугацаагаар явагдах мэс заслын үед
  - D. Шүд авах
  - E. Хатиг нээх
- /306./ Угийн мэдээгүйжүүлэлтийн үйлчлэх хүрээг заана уу?
- A. Шүднүүд
  - B. Эрүүний тал
  - C. Эрүүний салст
  - D. Дагз
  - E. Арьс
- /307./ Угийн мэдээгүйжүүлэлт хийхэд ямар урттай зүү ашиглах вэ?
- A. 3-4 см
  - B. 7-8 см
  - C. 10-15 см
  - D. 1-2 см
  - E. 18-20 см
- /308./ Вайсблатын аргаар II салааг мэдээгүйжүүлэхэд зүүг хаана хатгах вэ?
- A. Үений төвгөр
  - B. Шанаа түүшийн заадас
  - C. Чихний цэцэг, нүдний гадна өнцгийг холбосон шугамын гол
  - D. Онгрэйны шугам
  - E. Эрүү-далавчийн нугалаас
- /309./ Хэсгийн мэдээгүйжүүлэлтийн үед шууд илрэх ерөнхий хүндрэлийг нэрлэнэ үү?
- A. Обморок
  - B. Цус хурах
  - C. Ам ангайлт хязгаарлагдах
  - D. Цусан үжил
  - E. Ясны үрэвсэл
- /310./ Обморок гэж юу вэ?
- A. Тархины цусан хангамж дутмагшилд орох
  - B. Эсрэг төрөгчид харшлын урвал үзүүлэх
  - C. Ухаан алдаж булчингийн агшилтгүй болох
  - D. Ухаан алдах
  - E. Хөөрлийн байдалд орох
- /311./ Адреналины тунг хэтрүүлсэн үед юу хийх вэ?
- A. Судсаар 1 мл атропин
  - B. Судсаар 1 мл мезатон
  - C. Судсаар 1 мл норадреналин
  - D. Судсаар 2 мл атропин
  - E. Судсаар 2 мл норадреналин
- /312./ Коллапс гэж юу вэ ?
- A. Эсрэг төрөгчийн эсрэг харшлын урвал үзүүлэх
  - B. Ухаан алдаж булчингийн агшилтгүй болох

- C. Ухаан алдахгүйгээр судасны дутмагшилд орохыг хэлнэ  
D. Тархины цусан хангамж дутмагшилд орох  
E. Хөөрлийн байдалд орох
- /313./ Харшлын дайрлага ихэвчлэн хэзээ үүсэх вэ?  
A. Диатезийн  
B. Хордлогын  
C. Нойр булчирхайн архаг үрэвсэл  
D. Урьд нь харшлын урвал өгч байсан суурь дээр үүснэ  
E. Төрөлхийн
- /314./ Шүд яаралтайгаар авах заалтыг нэрлэнэ үү?  
A. Зөөлцийн хурц үрэвсэл  
B. Гүн цоорол  
C. Ясны хурц үрэвслийн голомт болж буй шүд  
D. Холбоосын хурц үрэвсэл  
E. Сурвалжийн уйланхай
- /315./ Шүд авах заалтыг нэрлэнэ үү?  
A. Зөөлцийн хурц үрэвсэл  
B. Гүн цоорол  
C. Холбоосын хурц үрэвсэл  
D. Холбоосын архаг үрэвсэл  
E. Цөгцний 1/3 хугарал
- /316./ Шүдийг төлөвлөгөөтэй авах заалтыг нэрлэнэ үү?  
A. ЭНО-ын буглаа, нэвчээсийн шалтгаан болж буй шүд  
B. Холбоосын хурц үрэвсэл  
C. Тэнхлэгийн дагуу хугарсан шүд  
D. Хагас болон бүрэн саатсан шүд  
E. Зөөлцийн хурц үрэвсэл
- /317./ Шүд үл авах заалтыг нэрлэнэ үү?  
A. Туяаны архаг өвчин  
B. Салстын өвчний сэдрэлт  
C. Жирэмсний дунд 6 сар  
D. Цөсний чулуутай  
E. Ходоодны архаг үрэвсэл
- /318./ Дээд, доод шүдний сурвалж авахад хэрэглэдэг туслах багажийг нэрлэнэ үү?  
A. Бор машин  
B. Шулуун бахь  
C. Зүү баригч  
D. Лимбергийн дэгээ  
E. Карапетяны гөнжүүр
- /319./ Жад хэлбэрийн бахиар ямар шүдийг авах вэ?  
A. Доод үүдэн шүднүүд  
B. Дээд араа шүднүүдийн ёзоор  
C. Дээд араа  
D. Доод агт араа  
E. Дээд бага араа
- /320./ 2.6-р шүдийг авах үед ганхуулах хөдөлгөөний анхны чиглэлийг тодорхойлно уу?  
A. Тагнай руу  
B. Хацар луу  
C. Урагш  
D. Арагш  
E. Доош
- /321./ 3.6-р шүдийг авах үед ганхуулах хөдөлгөөний анхны чиглэлийг тодорхойлно уу?  
A. Хацар луу  
B. Хэл рүү  
C. Урагш

- D. Арагш  
E. Доош
- /322./ 4.6-р шүдийг авахад ганхуулах хөдөлгөөний анхны чиглэлийг тодорхойлно уу?  
A. Хэл рүү  
B. Урагш  
C. Арагш  
D. Хацар луу  
E. Доош
- /323./ Шүд авах мэс ажилбарын үед өвчтөнийг яаж байрлуулах вэ?  
A. Доош  
B. Хэвтээ  
C. Хагас хэвтээ  
D. Хажуулдан  
E. Босоо
- /324./ Бахьны зөв байрлалыг тодорхойлно уу?  
A. Шүдний тэнхлэгтэй давхцуулсан байрлал  
B. Шүдний тэнхлэгтэй 40° налуу байрлал  
C. Нүүрний голын шугамтай параллель  
D. Онгрены шугамтай параллель  
E. Хэлний дагуу шугамаар
- /325./ Ёломын үрэвсэл ямар үүсгэгчээр үүсгэгдэх вэ?  
A. Цацраг мөөгөнцөр  
B. Цайвар спирохет  
C. Стрептококк  
D. Сүрьеэгийн савханцар  
E. Менингококк
- /326./ Ёломын үрэвсэл ямар замаар тархах вэ?  
A. Аман дотуур  
B. Цусаар  
C. Агаар дуслын замаар  
D. Гэмтсэн арьс салстаар  
E. Өөрөө өөрөөсөө
- /327./ Ёломын нууц үе хэд хоног вэ?  
A. 1-3 хоног  
B. 24 цаг  
C. 7 хоног  
D. 7-14 хоног  
E. 3 долоо хоног
- /328./ Ёломын үрэвсэл эхлэх үед хэт ягаан туяаг ямар тунгаар хэрэглэх вэ?  
A. Хэт улайх  
B. Сул улайх  
C. Бага улайх  
D. Дунд зэргийн улайх  
E. Их улайх
- /329./ ЭНО-ын хатигшлын үед хийгдэх хам эмчилгээг нэрлэнэ үү?  
A. Туяаны  
B. Тайвшруулах  
C. Бариа засал  
D. Даралт бууруулах  
E. Хордлого тайлах
- /330./ Нүүрний хатигны үед хэсгийн болон ерөнхий өөрчлөлтүүд ихсэхэд хийгдэх мэс заслын аргыг нэрлэнэ үү?  
A. Хатигийг зүсэх  
B. Үрэвслийн голомтод урсгуур тавих  
C. Хөлдөөх мэс засал



/331./ Мундас үүсэхэд нөлөөлөх өвчнийг нэрлэнэ үү

- A. Чихрийн шижин
- B. Үсний үрэвсэл
- C. Сэтгэцийн өвчнүүд
- D. Даралт ихсэх өвчин
- E. Ходоодны үрэвсэл

/332./ Хатиг үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлүүдийг нэрлэнэ үү?

- A. Эндоартрит
- B. Сэтгэцийн өвчнүүд
- C. Даралт ихсэх өвчин
- D. Биеийн эсэргүүцэл сулрах
- E. Ходоодны үрэвсэл

/333./ ЭНО-ын мундасыг ихэвчлэн ямар нянгууд үүсгэдэг вэ?

- A. Цацраг мөөгөнцөр
- B. Лефлерийн нян
- C. Цайвар спирохет
- D. Стафилококк, стрептококк
- E. Сүрьеэгийн савханцар

/334./ Нүүрний хатигны хэсэг газрын хүндрэлийг нэрлэнэ үү?

- A. Нүдэнд юм хоёр харагдах
- B. Хоншоорын хөндийн үрэвсэл
- C. . Буглах
- D. Ёломын үрэвсэл
- E. Эрүүний ясны хальсны үрэвсэл

/335./ Нүүрний хатигны ерөнхий хүндрэлийн үед ямар шинж илрэх вэ?

- A. Нүдэнд юм хоёр харагдах
- B. Хоншоорын хөндийн үрэвсэл
- C. Ёломын үрэвсэл
- D. Даралт ихсэх
- E. Цусан үжил

/336./ Хатигны үед илрэх шинжийг нэрлэнэ үү?

- A. Хэсэг газар арьс улайсан
- B. Нэвчдэс дээрх арьс хөхөвтөр өнгөтэй
- C. Нэвчдэс зөөлөн эдийн түвшинд байх
- D. Нягт нэвчдэс дээрх зөөлөн эд улаан өнгөтэй
- E. Голдоо идээт үхжилттэй улаан өнгийн нэвчдэстэй

/337./ Эрүүний ясны хальсны үрэвслийн үед ясны хальсыг нээгээд шарханд урсгуурыг хэдийд тавихвэ?

- A. 2 дахь хоногоос
- B. 3 дахь хоногоос
- C. 4 дахь хоногоос
- D. Зүслэгийн дараа шууд тавина
- E. 7 дахь хоногоос

/338./ Ясны хальсны үрэвслийн эмнэл зүйн гол шинж нь яаж илрэх вэ?

- A. . Нүүрний тэгш хэм алдагдах
- B. Бүх шүд хөдөлгөөнд орох
- C. Ам ангайлт хязгаарлагдах
- D. Хэлэн доорхи нугалаас хавдах
- E. Шилжих нугалаас улайж хавагнах

/339./ Ясны хальсны үрэвслийн үед зүслэгийг хаана хийх вэ?

- A. Эрүүний буланг тойрсон зүслэг хийх
- B. Оочийн доорх голын шугамаар зүслэг хийх
- C. Эрүү далавчны нугалаасны салст бүрхэвчинд зүслэг хийх
- D. Шилжих нугалаасны салст, ясны хальсыг зүсэх
- E. Эрүүн доогуур зүслэг хийх

/340./ Шүдний гаралтай эрүүний ясны хурц үрэвслийн хэсэг газрын шинж яаж илрэх вэ?

- A. Эрүүний бүх шүд хөдөлгөөнтэй болно
- B. Үрэвслийн тодорхой хил хязгааргүй нэвчдэс үүсч ачааллын шинж тэмдэг илэрнэ
- C. Муфт хэлбэрийн тодорхой хил хязгаартай нэвчдэс үүснэ
- D. Тодорхой хил хязгаартай үрэвслийн нэвчдэс үүсэх ба ачааллын шинж тэмдэг илрэхгүй

E. Нүүр муруйна

/341./ Шүдний гаралтай хурц үрэвслийн шалтгаан болж буй шүдэнд ямар арга хэмжээ авах вэ?

- A. Шүдийг авна
  - B. Шүдний хөндийг нээнэ
  - C. Шүдийг ломбодно
  - D. Шүдний зөөлцийг авна
  - E. Шүдийг буцааж суулгана
- /342./ Шүдний гаралтай ясны хурц үрэвслийн үед ясны төлжилтийг сайжруулахад хэрэглэгдэх эм аль нь вэ?

- A. Канамицин
  - B. Ампициллин
  - C. Линкомицин
  - D. Пенициллин
  - E. Эритромицин
- /343./ Үхжил давамгайлсан ясны архаг үрэвслийн үед рентген шинж тэмдэг хэдийд илрэх вэ?

- A. 30 дахь хоногоос
  - B. 25 дахь хоногоос
  - C. 20 дахь хоногоос
  - D. 14 дахь хоногоос
  - E. 7 дахь хоногоос
- /344./ Шүдний гаралтай ясны архаг үрэвслийн секвестр үүссэн үед ямар эмчилгээ хийх вэ?

- A. Эктоми мэс засал
  - B. Амны хөндийг эрүүлжүүлэх
  - C. Нянгийн эсрэг эмчилгээ
  - D. Шалтгаан болж буй шүд орчмын ясны хальсийг нээх
  - E. Нянгийн эсрэг эмчилгээ мөхлөнгөр эдийг хусах мэс засал
- /345./ Шүд авч байхад хоншоорын ёроолыг цоолох үед үрэвслийн шинж тэмдэггүй бол ямар арга хэмжээ авах вэ?

- A. Гайморостоми
  - B. Үечилсэн ажиглалт хяналтанд байх
  - C. Хөндийг халдваргүйжүүлэх уусмалаар угаах
  - D. Иодформтой чихээс шүдний оромд тавих
  - E. Цоорлыг хацрын салстаар далбан үүсгэж хаах
- /346./ Хоншоорын хөндий амны хөндийтэй харьцсан цоорхойг ямар аргаар хаах вэ?

- A. Филатовын гувруугаар хаах
  - B. Хацрын салстаар далбан үүсгэж хаах
  - C. Дээд уруулын салстаар хаах
  - D. Иодформтой чихээс болон хамгаалах ялтас
  - E. Чөлөөт арьс нөхөх
- /347./ Зөв байрлалтай агт арааны перикоронаритийн үед ямар арга хэмжээ авах вэ?

- A. Шүдийг авна
- B. Секвестрэктоми хагалгаа хийнэ
- C. Цөгц хучсан буйлыг зүсэж авна

- D. Лидокайнаар шингээх мэдээ алдуулалт хийнэ  
E. Шилжих нугалааст зүслэг хийнэ
- /348./ Доод агт араа буруу байрлалтай үед мэс заслын зүслэгийг хаана хийх вэ?  
A. Хэлэн талын шилжих нугалаасаар  
B. Үүдэвч талын шилжих нугалаасаар  
C. 2-р их арааны голоос доош хацар талын шилжих нугалаас руу  
D. 2-р их арааны голоос доош хэлэн талын шилжих нугалаас руу  
E. 1-р их арааны голоос үүдэвч талын шилжих нугалаас руу
- /349./ Аль нэвчээсийн үед залгих үйл ажиллагаа хүндрэлтэй болдог вэ?  
A. Чамархайн  
B. Шанааны  
C. Хацрын  
D. Зажлуурын булчин доорх  
E. Эрүү далавчны зайн
- /350./ Аль нэвчээсийн үед ам ангайлт эрс хязгаарлагдах вэ?  
A. Шанааны  
B. Эрүүн доорх  
C. Ухархайн доорх  
D. Хацрын  
E. Эрүү далавчны зайн
- /351./ Булчирхайн гаралтай нэвчээсийн шалтгааныг нэрлэнэ үү?  
A. Идээлсэн хатиг  
B. Сурвалжийн оройн үрэвсэл  
C. Шүлсний булчирхайн цулын үрэвсэл  
D. Бусад хэсгээс үрэвсэл тархаснаас  
E. Тунгалгийн зангилаанаас цааш үрэвсэл тархаснаас
- /352./ Амны ёроолын нэвчээсийн үед зүслэгийг хаагуур хийх вэ?  
A. . Оочны доогуур  
B. Эрүүний буланг тойрсон  
C. Эрүү далавчны нугалаасаар  
D. Эрүүний ирмэгийг дагуулан эрүүн доогуур  
E. Эрүүний ирмэгийн зэрэгцээ булангаас булан хүртэл
- /353./ Хоншоорын Лефор III хугарлын адил нэршлийг хэлнэ үү?  
A. Суурийн доогуурх хугарал  
B. Ухархайн доогуурх хугарал  
C. Түүшин сэртэн хугарч салах  
D. Шанаа яс салах  
E. Ухархай ба суурийн доогуурх хугарал
- /354./ Шанаа ясны хугарлын үед ам ангайлт хязгаарлагдах шалтгааныг хэлнэ үү?  
A. Цус хурах  
B. Хугарал зөрөх  
C. Үрэвслийн процесс  
D. Зажлуурын булчин гэмтэх  
E. Эрүү-чамархайн үений үрэвсэл
- /355./ Шанаа ясны хугарлын үед нүдэнд юм хоёр харагдах шалтгааныг хэлнэ үү?  
A. Нүдний алим гэмтэх  
B. Үрэвслийн урвал  
C. Нүдний алим зөрөх, хүүхэн харааны тэгш хэмт байрлал алдагдах  
D. Нүдний мэдрэл гэмтэх  
E. Ухархайд цус хурах
- /356./ Эрүүний мултралын хэлбэр аль нь вэ?  
A. Дунд  
B. Дээд

- C. Урд
- D. Зүүн
- E. Доод

/357./ Эрүүний хугарлын үед гарах эмнэл зүйн үндсэн шинж аль нь вэ?

- A. Толгой өвдөх
- B. Хамраас цус гарах
- C. Эрүү эмгэг хөдөлгөөнтэй болох
- D. Хоншоор эмгэг хөдөлгөөнтэй болох
- E. Түүшин сэртэнгийн салст урагдах

/358./ Хоншоорын хугарлын үед гарах эмнэл зүйн үндсэн шинж тэмдэг аль нь вэ?

- A. Толгой өвдөх
- B. Хамраас цус гарах
- C. Эрүү эмгэг хөдөлгөөнтэй болох
- D. Хоншоор эмгэг хөдөлгөөнтэй болох
- E. Түүшин сэртэнгийн салст урагдах

/359./ Суурь ясны хугарлын үед зайлшгүй гарах шинж аль нь вэ?

- A. Нугасны шингэн гарах
- B. Хамраас цус гарах
- C. Эрүү эмгэг хөдөлгөөнтэй болох
- D. Хоншоор эмгэг хөдөлгөөнтэй болох
- E. Чихний гадна сувгаас цус гарах

/360./ Эрүүний үений сэртэнгийн хоёр талын хугарлын үед гарах шинжийг нэрлэнэ үү?

- A. Заалхай зуулт
- B. Хамраас цус гарах
- C. Түүшин сэртэнгийн салст урагдах
- D. Хугарсан талын арааны хазалт өөрчлөгдөх
- E. Хугарлын эсрэг талын арааны хазалт өөрчлөгдөх

/361./ Шанаа ясны хугарлын үед гарах шинжийг нэрлэнэ үү?

- A. Хамрын хэлбэр алдагдах, цус хурах
- B. Шанаа орчим цус хурах
- C. Доод зовхинд цус харвах
- D. Хамраас цус гарах, толгой эргэх
- E. Шанаа ясны орчим хонхойх, нүдэнд юм хоёр харагдах

/362./ Ухархайн доогуурх хугарлын үед хоншоор ясанд үүсэх зөрүүг заана уу?

- A. Доошоо ба арагш
- B. Дээш ба урагш
- C. Дотор хажуу тал руу ба урагш
- D. Гадна хажуу тал руу ба дээш
- E. Доошоо ба дээш

/363./ Түлэгдлийн 1 дүгээр зэргийн үед арьсны аль хэсэг гэмтэх вэ?

- A. Арьс бүрэн гэмтэх
- B. Арьс ба арьсан доорх эд гэмтэх
- C. Өнгөц эпидермис гэмтэх
- D. Өнгөц эпидермис ба хялгасан судас
- E. Эпидермисийн бүх давхрага гэмтэж арьсны дайвар эрхтэн

хадгалагдах

/364./ Эрүү-нүүр орчмын шархны анхдагч цэгцлэлт хийх онцлогийг хэлнэ үү?

- A. Халдваргүйжүүлэх уусмалаар угааж, оёдол тавьж боолт хийх
- B. Цусыг тогтоож, ариун уусмалаар угааж оёдол тавьж, боолт хийх
- C. Цусны нөжийг аваад үхжсэн эдийг өөлж, шарханд урсгуур тавих
- D. Халдварын эсрэг уусмалаар угааж, үхжсэн эдийг авч шархыг оёх
- E. Шархны үхжсэн эдийг хямгатай өөлж, анхдагч нөхөн сэргээлт хийх

/365./ Чихний гадна суваг ба хамраас цус гарахад нугасны шингэн агуулагдаж буйг мэдэх шинжийг нэрлэнэ үү?

- A. Малевичийн шинж
  - B. Вассерманы урвал илэрнэ
  - C. Толбо давхардалтын шинж
  - D. Цусан дахь альбумин буурах
  - E. Хөхлөг сэртэн орчим шажигнах
- /366./ Хоншоорын хугарлын үед ачааллын шинжийг хаана үзэх вэ?
- A. Шанаа ясыг доороос дээш дарах
  - B. Шүдийг зуулгаж байгаад оочин доороос дарах
  - C. Оочны дороос дээш дарах
  - D. Амыг хагас ангайлгасан үед ооч орчим дороос дээш дарах
  - E. Далавч сэртэн орчим дороос дээш дарах
- /367./ Нүүрний шархны эрт үеийн анхдагч цэгцлэлтийг хийх хугацааг заана уу?
- A. 1 цагийн дотор
  - B. 8-12 цаг
  - C. 24-48 цаг
  - D. 3 дахь хоног
  - E. 8 дахь хоног
- /368./ Нүүрний шархны хожуу анхдагч цэгцлэлтийг хийх хугацааг заана уу?
- A. 8-12 цаг
  - B. 24 цаг
  - C. 48 цаг
  - D. 8 дахь хоног
  - E. 14 дэх хоног
- /369./ Гурамсан мэдрэлийн өвдөлтийн зовиурыг нэрлэнэ үү?
- A. Венсаны шинж тэмдэг
  - B. Урт хугацааны мэдээгүйжүүлэлт
  - C. Байнгын өвдөлт
  - D. Богино хугацааны мэдээгүйжүүлэлт
  - E. Үе үе хүчтэй өвдөх
- /370./ Гурамсан мэдрэлийн өвдөлтийн эмнэл зүйн шинжийг нэрлэнэ үү?
- A. 15-30 минутын хугацаатай чих, чамархай руу дамжиж хүчтэй хатгаж өвдөх
  - B. Мэдрэл дээр дарахад эрчим нь сулрахгүйгээр үргэлжлэн өвдөх
  - C. Хамраас ялгасад гарах ба хоншоорын ясандаа битүү өвдөх
  - D. Үргэлжилсэн хатгуулж өвдөх нь чих рүүгээ дамжиж, эрүүний үе дуугарах
  - E. Мэдрэхүй алдагдалгүйгээр гэнэтийн цочруулаас үүссэн богино хугацааны хүчтэй өвдөлт
- /371./ Гурамсан мэдрэлийн үрэвслийн эмнэл зүйн шинж аль нь вэ?
- A. 15-30 минутын хугацаатай чих, чамархай руу дамжиж хүчтэй хатгаж өвдөх
  - B. Мэдрэл дээр дарахад эрчим нь сулрахгүйгээр үргэлжлэн өвдөх
  - C. Хамраас ялгасад гарах ба хоншоорын ясандаа битүү өвдөх
  - D. Үргэлжилсэн хатгуулж өвдөх нь чих рүүгээ дамжиж, эрүүний үе дуугарах
  - E. Мэдрэхүй алдагдалгүйгээр гэнэтийн цочруулаас үүссэн богино хугацааны хүчтэй өвдөлт
- /372./ Гурамсан мэдрэлийн өвдөлтийн үед хийх мэс заслын эмчилгээг нэрлэнэ үү?
- A. Мэдрэл тайрах
  - B. Трахеостоми
  - C. Спирт шахах
  - D. Мэдээ алдуулагчтай хориг хийх
  - E. Таталтын эсрэг эм өгөх
- /373./ Гурамсан мэдрэлийн өвдөлтийн үед спирт шахах эмчилгээ хийх заалтыг заана уу?
- A. Мэдээ алдуулагчтай хориг
  - B. Оношлогооны эхэн үед
  - C. Эмийн үр дүнгүй эмчилгээний дараа
  - D. Таталтын эсрэг эм өгөхийн өмнө
  - E. Мэс заслын эмчилгээний өмнө

- /374./ Гурамсан мэдрэлийн өвдөлтийн үед спирт шахах газрыг заана уу?
- A. Мэдрэл орчим
  - B. Өвдөлтийн бүсэд
  - C. Нэвчүүлэх замаар
  - D. Зөөлөн эдэд
  - E. Шилжих нугалаас орчим
- /375./ Гурамсан мэдрэлийн өвдөлтийн үед хэдэн хувийн спирт хэрэглэх вэ?
- A. 40%
  - B. 50%
  - C. 60%
  - D. 80%
  - E. 96%
- /376./ Гурамсан мэдрэлийн өвдөлтийн мэс заслын эмчилгээг нэрлэнэ үү?
- A. Невроэкзерез
  - B. Остеотоми
  - C. Гайморотоми
  - D. Экзартикуляци
  - E. Алколизаци
- /377./ Гурамсан мэдрэлийн үрэвслийн шалтгааныг заана уу?
- A. Цусны замаар
  - B. Харшил
  - C. Гэмтэл
  - D. Агаар дусал
  - E. Удамшил
- /378./ Гурамсан мэдрэлийн үрэвслийн шинж тэмдгийг заана уу?
- A. Богино хугацаанд хүчтэй өвдөнө
  - B. Үе үе хүчтэй өвдөнө
  - C. Үргэлжлэн өвдөнө
  - D. Өрөмдөх мэт
  - E. Цочирдсоноос
- /379./ Гурамсан мэдрэлийн үрэвслийн эмнэл зүйн шинжийг нэрлэнэ үү?
- A. Үрэвссэн мэдрэл дээр дарахад өвдөлт улам хүчтэй үргэлжлэнэ
  - B. Цахилгаанд цохиулах мэт
  - C. Хоромхон хугацаанд
  - D. Шүд өвдөх мэт өвдөнө
  - E. Өрөмдөх мэт өвдөнө
- /380./ Гурамсан мэдрэлийн үрэвслийн үед хэт мэдрэгжилт ажиглагдах уу?
- A. Ажиглагддаггүй
  - B. Ажиглагддаг
  - C. Үе үе хүчтэй өвдөнө
  - D. Гурамсан мэдрэлийн өвдөлтийн үед ажиглагддаг
  - E. Өвдөлтийн үед бага зэрэг ажиглагддаг
- /381./ Гурамсан мэдрэлийн үрэвслийн үед мэдээгүйжих шинж ажиглагдах уу?
- A. Ажиглагддаг
  - B. Бага зэрэг
  - C. Үе үе хүчтэй өвдөнө
  - D. Гурамсан мэдрэлийн өвдөлтийн гол шинж
  - E. Огт мэдрэгддэггүй
- /382./ Гурамсан мэдрэлийн үрэвслийн эмийн эмчилгээг нэрлэнэ үү?
- A. Мэдрэл тайрах мэс засал
  - B. Мэдрэл авах мэс засал
  - C. Үрэвслийн эсрэг
  - D. Новокаинтай хориг хийх
  - E. Спиртээр хориг хийх
- /383./ Гурамсан мэдрэлийн үрэвслийн эмийн бус эмчилгээг нэрлэнэ үү?

- A. Новокаинтай хориг хийх
  - B. . Спиртээр хориг хийх
  - C. Мэдрэл тайрах
  - D. Мэдрэл авах
  - E. Физик эмчилгээ
- /384./ Гурамсан мэдрэлийн үрэвслийн үед мэдээгүйждэг бүсийг заана уу?
- A. Зовхи
  - B. Хацар
  - C. Буйл
  - D. Нүд
  - E. Хэл
- /385./ Гахайн хавдарт өртөх шүлсний булчирхай аль нь вэ?
- A. Жижиг шүлсний булчирхай
  - B. Чихалзуурын
  - C. Хэлэн доорхи
  - D. Эрүүн доорх
  - E. Гүйлсэн булчирхай
- /386./ Гахайн хавдрын үеийн шүлсний ялгаралтын хэмжээг заана уу?
- A. Буурах
  - B. Хэвийн
  - C. Ихсэх
  - D. Шүлс огт ялгарахгүй
  - E. Хэт ихсэх
- /387./ Гахайн хавдрын хэсэг газрын эмчилгээг нэрлэнэ үү?
- A. Хүйтэн жин
  - B. Бөглөрүүлэх
  - C. Бигнүүр
  - D. Хөлдөөх
  - E. Спирт шахах
- /388./ Шүлсний булчирхайн хурц үрэвслийн үеийн шүлсний байдлыг тодорхойлно уу?
- A. Тунгалаг, зунгааралдсан
  - B. Тунгалаг, шингэн
  - C. Булингартай, зунгааралдсан
  - D. Цусан судалтай, өтгөн
  - E. Тунгалаг
- /389./ Шүлсний булчирхайн хурц үрэвслийн эмчилгээний зарчмыг нэрлэнэ үү?
- A. Идээт голомтыг нээх
  - B. Гэмтсэн булчирхайг авах
  - C. Шүлс ялгаралтыг багасгаж, үрэвсэл дарах
  - D. Шүлс ялгаралтыг ихэсгэж, үрэвсэл дарах
  - E. Спирт шахах
- /390./ Шүлсний булчирхайн идээт үрэвслийн үед гарч болох хэсэг газрын хүндрэл аль нь вэ?
- A. Ясны хальсны үрэвсэл
  - B. Тархины хальсны үрэвсэл
  - C. Мэдрэлийн өвдөлт
  - D. Буглаа
  - E. Хоншоорын хөндийн үрэвсэл
- /391./ Шүлсний булчирхайн архаг үрэвсэл аль нь вэ?
- A. Шегрений хам шинж
  - B. Микуличийн өвчин
  - C. Гахайн хавдар
  - D. Шүлсний булчирхайн завсрын эдийн архаг үрэвсэл
  - E. Шүлсний булчирхайн уйланхай
- /392./ Шүлсний булчирхайн цуллагын архаг үрэвслийн шинж аль нь вэ?
- A. Завсарын эд хайлах

- B. Цуллаг эд нэлэнхүйдээ хавдах
- C. Олон жижиг хөндий үүсэх
- D. Завсарын эдийн ургалт
- E. Хатингаршил

/393./ Шүлсний булчирхайн цуллагын архаг үрэвслийн үеийн хавдарын байдлыг тодорхойлно уу?

- A. Барзгар
- B. Гөлгөр
- C. Өөрчлөлтгүй
- D. Дююитрены шинж
- E. Венсаны шинж

/394./ Шүлсний булчирхайн завсрын эдийн архаг үрэвслийн үед хавдрын гадаргуугийн байдал ямар байх вэ?

- A. Барзгар
- B. Гөлгөр
- C. Өөрчлөлтгүй
- D. Дююитрены шинж
- E. Венсаны шинж

/395./ Шүлсний булчирхайн ерөнхий цоргоны үрэвслийн үед аль хэсэг гэмтэх вэ?

- A. Завсарын эд
- B. Цуллаг эд
- C. Ерөнхий цорго
- D. Булчирхай орчмын тунгалгийн зангилаа
- E. Булчирхайн зэргэлдээх эд

/396./ Шүлсний булчирхайн цоргоны үрэвслийн үед тодотгогч бодистой рентген зургийн шинжийг нэрлэнэ үү?

- A. Гол цорго өргөсөх
- B. Цоргонуудын лонхон өргөсөлт
- C. Бүх зэрэглэлийн цоргоны нарийсалт
- D. Булчирхайд олон тооны хөндийтэй
- E. Бүх зэрэглэлийн цоргонууд өргөснө

/397./ Шүлсний булчирхайн цуллаг эдийн архаг үрэвслийн үед тодотгогч бодистой рентген зургийн шинжийг нэрлэнэ үү?

- A. Гол цорго өргөсөх
- B. Цоргонуудын лонхон өргөсөлт
- C. Бүх зэрэглэлийн цоргоны нарийсалт
- D. Булчирхайд олон тооны хөндийтэй
- E. Бүх зэрэглэлийн цоргонууд өргөснө

/398./ Шүлсний булчирхайн завсарын эдийн үрэвслийн үед тодотгогч бодистой рентген зургийн шинжийг тодорхойлно уу?

- A. Гол цорго өргөсөх
- B. Цоргонуудын лонхон өргөсөлт
- C. Бүх зэрэглэлийн цоргоны нарийсалт
- D. Булчирхайд олон тооны хөндийтэй
- E. Бүх зэрэглэлийн цоргонууд өргөснө

/399./ Эрүүл шүлсний булчирхайн тодотгогч бодистой рентген зураг авахад шаардагдах бодисын хэмжээний хэвийн үзүүлэлтийг заана уу?

- A. 0.1 мл
- B. 0,5 мл
- C. 0.8-1 мл
- D. 1.5 мл
- E. 2 мл

/400./ Эрүүл шүлсний булчирхайнаас тодотгогч бодис гадагшлах хэвийн хугацааг заана уу?

- A. 12 цаг
- B. 24-48 цаг



- C. 72 цаг
- D. 7 хоног
- E. 1 сар түүнээс дээш

/401./ Шүлсний булчирхайн завсрын эдийн үрэвслийн үед хэрэглэх тодотгогч бодисын хэмжээг тодорхойлно уу?

- A. Нормдоо
- B. Нормоос их
- C. Нормоос бага
- D. 15 мл
- E. 20 мл

/402./ Шүлсний булчирхайн цуллагын эдийн үрэвслийн үед хэрэглэх тодотгогч бодисын хэмжээг тодорхойлно уу?

- A. Нормдоо
- B. Нормоос их
- C. Нормоос бага
- D. 15 мл
- E. 20 мл

/403./ Шүлсний булчирхайн цоргоны үрэвслийн үед хэрэглэх тодотгогч бодисын хэмжээг тодорхойлно уу?

- A. Нормдоо
- B. Нормоос их
- C. Нормоос бага
- D. 15 мл
- E. 20мл

/404./ Шүлсний булчирхайн завсарын эдийн архаг үрэвслийн үеийн эмчилгээний аргыг заана уу?

- A. Калий иод
- B. . Пирогенол
- C. Антибиотик
- D. Сульфаниламид
- E. Өвчин намдаах

/405./ Пирогенолын хамгийн тохиромжтой тунг заана уу?

- A. 10 МПД
- B. 15 МПД
- C. 20 МПД
- D. 25 МПД
- E. 30 МПД

/406./ Шүлсний булчирхайн цоргын үед ямар эмийн бодис хэрэглэх вэ?

- A. Атропин сульфат
- B. Галантамин
- C. Пилокарпингидрохлорид
- D. Кали иод
- E. Пирогенол

/407./ Шүлс ялгаралтыг сайжруулах эмийн бодис аль нь вэ?

- A. Атропин сульфат
- B. Пилокарпингидрохлорид
- C. Хлоргексидин
- D. Иодит кали
- E. Хлорт кальци

/408./ Шүлс ялгаралтыг бууруулах эмийн бодис аль нь вэ?

- A. Атропин сульфат
- B. Пилокарпин гидрохлорид
- C. Хлоргексидин
- D. Иодит кали
- E. Хлорт кальци

/409./ Шүлсний цоргоны үед хэрэглэх атропины уусмалын хувийг тодорхойлно уу?

- A. 0.1%
- B. 0.2%
- C. 0.5
- D. 1%
- E. 2%

/410./ Шүлсний цоргоны үед хэрэглэх атропины уусмалын нэг удаагийн тунгийн хэмжээг тодорхойлно уу?

- A. 0.1 мл
- B. 0.5 мл
- C. 1 мл
- D. 2 мл
- E. 5 мл

/411./ Эрүүний үйл ажиллагааны алдагдлын үед хаана ямар өөрчлөлт гарах вэ?

- A. Чихний хэлбэр алдагдах
- B. Нүүрний хэлбэр алдагдах
- C. Хэлний хэлбэр алдагдах
- D. Хүзүүний хэлбэр алдагдах
- E. Нүдний хэлбэр алдагдах

/412./ Эрүүний үений толгойн хөдөлгөөний үений хонхортой харьцуулах замын уртыг тодорхойлно уу?

- A. 10 мм
- B. 12 мм
- C. 15 мм
- D. 17 мм
- E. 20 мм

/413./ Эрүүний үений толгойн хөдөлгөөний зээрэнцэгтэй харьцуулах замын уртыг тодорхойлно уу?

- A. 4 мм
- B. 6 мм
- C. 8 мм
- D. 10 мм
- E. 12 мм

/414./ Эрүүний үений үрэвслийн ангилалыг нэрлэнэ үү?

- A. Халдварын гаралтай
- B. Шүдний гаралтай
- C. Булчирхайн гаралтай
- D. Харшлын гаралтай
- E. Цусны замаар

/415./ Эрүүний үений өвөрмөц үрэвслийн шалтгаан аль нь вэ?

- A. Цацраг мөөгөнцөр
- B. Хэрлэгийн хурцдал
- C. Уушигний үрэвсэл
- D. Нэвчээс
- E. Цусан замаар

/416./ Эрүүний үений өвөрмөц үрэвслийн шалтгаан аль нь вэ?

- A. Тэмбүү
- B. Хэрлэгийн хурцдал
- C. Уушигний үрэвсэл
- D. Нэвчээс
- E. Цусан замаар

/417./ Эрүүний үений хурц үрэвслийн зайлшгүй ялгах өвчин аль нь вэ?

- A. Хоншоорын хөндийн үрэвсэл
- B. Хамрын ясны хугарал
- C. Хоншоорын хугарал

- D. Гурамсан мэдрэлийн өвдөлт  
E. Ухархайн нэвчээс
- /418./ Эрүүний үений хурц үрэвслийн зайлшгүй ялгах өвчин аль нь вэ?  
A. Хоншоорын хөндийн үрэвсэл  
B. Ясны хальсны үрэвсэл  
C. Хоншоорын хугарал  
D. Эрүүний үений өвдөлтөт хам шинж  
E. Шаамий зуулт
- /419./ Цусаар дамжин халдварласан эрүүний үений үрэвсэл нь хэдэн насанд голчлон тохиолдох вэ?  
A. Бага насны хүүхдэд  
B. Насанд хүрэгчдэд  
C. Сургуулийн насанд  
D. Өндөр настанд  
E. Нярай хүүхдэд
- /420./ Эрүүний үений артрозын хэлбэрийг тодорхойлно уу?  
A. Идээт  
B. Хэлбэр алдагдах  
C. Үхжилт  
D. Зөөлрөх  
E. Хатуурсан
- /421./ Эрүүний үений бороо үүсэх гол шалтгааныг нэрлэнэ үү?  
A. Эрүүний үений үрэвсэл  
B. Хөхлөг сэртэнгийн үрэвсэл  
C. Зажлуур булчин орчмын эслэгийн үрэвсэл  
D. Эрүүний их биений хугарал  
E. Идээт үрэвсэл
- /422./ Хавдарын урьдал өвчин гэж юу вэ?  
A. Үрэвслийн нэвчдэс  
B. Тэжээл алдагдсан тогтвортой бус нөхөнөлжилт  
C. Үрэвссэн хоргүй хавдар  
D. Нүүрний зөөлөн эдийн хурц шархлаа, үхжилт процесс  
E. Гэмтэл
- /423./ Уруулын улааны хавдарын урьдал өвчнийг заана уу?  
A. Ёлом  
B. Дулааны ба химийн түлэгдэлт  
C. Предраковый меланоз, салстын доорх фиброз  
D. Гиперкератоз, хейлит Манганотти  
E. Боуэны өвчин, нөсөөт ксеродерми, актинический кератоз
- /424./ Боуэны өвчний эмнэл зүйн шинжийг нэрлэнэ үү?  
A. Төлжилт, цус гаралт муутай 2-3-н шархлаа  
B. Шархлаат гадаргуутай шүүдэст эд  
C. Газрын зураг шиг, тавтай, хатингаршсан нягт товруу  
D. Нягт шингэн хайрстай хязгаарлагдмал эвэршилт  
E. Хучуур эдийн төвшингөөс 3-5 мм өргөгдсөн барзгар гадаргуутай өвчтэй зангилаа
- /425./ Хүзүүний төрөлхийн уйланхайн эмнэл зүйн гол шинжийг тодорхойлно уу?  
A. Хүзүүний арьс зузаарах  
B. Халуурах  
C. Базлалт бүхий өвдөлт  
D. Тимолын нэмэх урвал  
E. Дугуй хэлбэртэй хавдар
- /426./ Хүзүүний голын цоргыг өвчиж авахдаа хамт тайрч авах шаардлагатай эрхтэнийг заана уу?

- A. Бамбайн мөгөөрс
  - B. Гүйлсэн булчирхай
  - C. Хэлэн доорх ясны хэсгээс
  - D. Эрүүн доорх шүлсний булчирхай
  - E. Эрүүн доорх шүлсний булчирхайн цорго
- /427./ Амелобластомын рентген шинжийг тодорхойлно уу?
- A. Хайлсан сахар мэт ясны эдийн өөрчлөлт
  - B. Хөвөн шил мэт ясны эдийн өөрчлөлт
  - C. Тодорхой хил хязгаартай, дундуураа ясан таславчтай, ясны гадна ялтсыг нилд нь хамарсан шимэгдэлт
  - D. Ясны олон голомтот сөнөрөл
  - E. Ясны хэмт эдийг нилэнхүйд нь хамарсан сөнөрөл
- /428./ Зөөлөн одонтомын зонхилж байрлах байрлалыг заана уу?
- A. Доод араа орчимд
  - B. Дээд араа орчимд
  - C. Доод бага араа орчимд
  - D. Доод соёо орчимд
  - E. Дээд соёо орчимд
- /429./ Аварга эст хавдарын эмнэл зүйн шинжийг нэрлэнэ үү?
- A. Сорвижилтийн улмаас ам зуурах
  - B. Шинж тэмдэг илрэхгүй
  - C. Ясны хальсны үрэвсэл хэлбэрээр үе үе үрэвсэх
  - D. Хэд хэдэн шүдний орчим эмзэглэлтэй хатуу нэвчдэстэй
  - E. Яс барзгар гадаргатай эмзэглэлгүй хавдаж, тэр хэсгийн шүд хөдөлгөөнтэй болох
- /430./ Эозинофильный гранулёмын эхний шатны эмнэл зүйн шинжийг нэрлэнэ үү?
- A. Буйлны шархлаат үрэвсэл, стоматит(салстын өвчин)
  - B. Ясны хальсны үрэвсэл хэлбэрээр үе үе үрэвсэх
  - C. Хэд хэдэн шүдний орчим эмзэглэлтэй хатуу нэвчдэс үүсэх
  - D. Яс барзгар гадаргатай эмзэглэлгүй төвийх, тэр хэсгийн шүд хөдөлгөөнтэй байх
  - E. Буйл загатнаж цус гарах , эрүүл шүд хөдөлгөөнтэй болох,шүдний сурвалж ил гарах
- /431./ Лимфангиомын эмнэл зүйн гол онцлог шинжийг тодорхойлно уу?
- A. Лугших
  - B. Үрэвсэх
  - C. Шохойжсон эд үүсэх
